

ӨВӨР МОНГОЛ БОЛОН МОНГОЛ УЛСЫН ХООРОНДОХ ЭДИЙН ЗАСАГ, ХУДАЛДААНД ХОЛБОГДОХ ЗАРИМ АСУУДЛЫН ТУХАЙ

*Н.Улаан-Од**

2006 оны 11 сарын 22-27 өдрийн хооронд Монгол Улсын ерөнхий сайд М.Энхболд манай улсад албан ёсны айлчлал хийсэн явдал нь, хоёр улсын эдийн засаг, хөрөнгө оруулалт, эрчим хүч, зам харилцаа зэрэг олон салбарт хамтын ажиллагааг улам эрчимжүүлэхэд чухал ач холбогдол өгсөн юм.

Монгол Улсын Үйлдвэр, худалдааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Нямсүрэн тэргүүтэй эдийн засаг, худалдааны төлөөлөгчдийн бүлгэм 2006.12.4-7-ны өдөр хүртэл Хөх хотод хуралдсан “Хоёр талын Байнгын зөвлөлдөх ажлын хэсгийн 7 дугаар хурал”-д оролцон үг хэлсэн явдал нь, Өвөр Монгол болон Монгол Улсын хоорондох эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны нэлээд олон тодорхой асуудал дээр үргэлжлэн хамтран ажиллах шинэ боломжуудыг нээсэн юм.

Нэг. Хамтын ажиллагааны хөгжлийн өнөөгийн байдал

Сүүлийн жилүүдэд Өвөр Монгол болон Монгол Улсын хоорондох эдийн засаг, худалдааны харилцаа хөгжиж, хамтын ажиллагаа тасралтгүй өсөн нэмэгдсээр байна. Өвөр Монголын Худалдааны явдлын танхимын нэгтгэсэн тооцоогоор Монгол Улсад Хятадаас оруулж буй импортын барааны үнийн дүнгээр манай орон ойролцоогоор 70 хувийг эзэлж байна. Өвөр монголын хил дотор Хятад, Монголын хилийн боомт 8, улирлын чанартай түр ажиллагаатай боомт 5 байдаг нь Хятад, Монголын хоорондын импорт, экспортын барааны гол чухал төв болсон юм. Ойрын жилээс хоёр тал эдийн засаг, худалдаа, соёл, эрүүл мэнд, боловсрол, шинжлэх ухаан, аялал жуулчлал, зам харилцааны салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх үүднээс доорхи асуудлын хүрээнд санал солилцон хамтран ажиллаж байна.

Хоёр. Өвөр монголын талаас тавьдаг гол саналууд гэвэл:

1. Манай талаас Монголд хөдөлмөр эрхэлдэг мэргэжилтний тоог нэмэгдүүлэх, бичиг баримтыг нь хялбарчлах, хөдөлмөр эрхлэх татварыг нь бууруулах, хууль бусаар хөдөлмөр эрхлэх явдлыг таслан зогсоох;

* Н.Улаан-Од -БНХАУ-ын Өвөр Монголын Их Сургуулийн дэд профессор, докторант

2. Монголын тал өөрийн хил гаалийн бодлого, харилцаа холбооны журам, мэдээлэл солилцох арга барил, хоёр талын уулзалтын товгыг урьдчилан мэдэгдэж байх;

3. Манай талын Нарийн Сухайтын нүүрсний ордоос Цэхэ, Шивээхүрэн боомт хүртлэх ачаа тээврийн зам байгуулах асуудлыг Монголын тал түргэн шийдвэрлэж өгөх;

4. Монголын Дорнод аймгийн Тамсагын нутагт газрын тос олборлож байгаа манай газрын тосны “Дачин Тамсаг” компанид Хятадаас цахилгаан эрчим хүч нийлүүлэх хүсэлтэд тодорхой хариу өгөх;

5. Манай талаас, “Чинхуа Мак нарийн сухайт” компанийн хилээр оруулах машин механизм болон тээвэрлэлтэд олон улсын тээвэрлэлтийн тусгай зөвшөөрөл, олон улсын гэрчилгээ олгох асуудлыг зүй зохистой шийдвэрлэх;

6. Манай талаас, Монголд хөрөнгө оруулсан томоохон аж ахуй нэгжүүдийн удирдлага болон нарийн мэргэжлийн ажилчдын харьцааг нэмэгдүүлэх;

7. Хоёр тал хилээр орж гарч байгаа хүнсний бүтээгдэхүүний тээвэрлэх хэрэгсэл, эрүүл ахуйн байдал, хүнсний эрүүл ахуйн болон аюулгүй байдлын баталгааг найдвартай болгон сайжруулах талаар хамтран ажиллах;

8. Манай талаас, ӨМӨЗО-ны Баяннуур хот болон Хятадын “Шэнь хуа” групп Монголын талтай Таван толгойн нүүрсний орд дээр хамтран ажиллах явдлыг чухалчлан үзэх;

9. Монгол Улсад малын шүлхий өвчин заримдаа гарч байгаатай холбогдуулан шүлхий нэвтрэхээс сэргийлж Монгол Улсаас малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн импортлохыг хориглосон. Үүнээс болж малын гаралтай түүхий эдийн импорт багасах хандлагатай байгаа. Монголын талаас малын шүлхий өвчний голомтыг арилгах арга хэмжээг тууштай авч улмаар хоёр орны малын гаралтай бүтээгдэхүүний худалдааг хэвийн байдалд оруулах;

10. Манай талаас, Цэхэ, Шивээхүрэн боомт, Нарийн Сухайтын нүүрсний уурхайн төмөр зам болон хатуу хучилттай авто зам барих төслийн зөвшөөрлийг шийдэж олгох;

11. Цэхэ, Шивээхүрэн боомтуудаар ачаа тээвэрлэх боломжыг нэмэгдүүлэх, боомтуудын хоорондох авто зам нь өнөөгийн хэрэгцээ, шаардлагыг хангахгүй байна. Иймээс Цэхэ, Шивээхүрэн боомтуудад ачаа тээврийн шинэ авто зам байгуулах;

12. Мандал боомтоос - Дорноговь аймгийн Хатанбулаг сум, Мандал боомтоос - Сайншанд хүртлэх авто зам барих, мөн Мандал боомтоос - Зүүнбаян хүртлэх төмөр зам барих зөвшөөрөл олгох;

13. Манай тал хоёр орны хил дагуух иргэдийн найрсаг харилцааг нэмэгдүүлэх, хил дагуух худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх үүднээс Өмнөговь аймгийн нутаг дахь Багамод - Бүдүүнмод, Өлзий - Цагаандэл боомтыг нээн зам тавих;

14. Хятад, Монгол хоёр тал Рашаант - Сүмбэр боомтод гүүр барихаар тогтсон. Манай тал 2007.4.1-11.1-ний өдрүүдэд тус боомтыг түр нээж гүүр засах болон барихад шаардагдах машин механизм, тоног төхөөрөмж, барилгын материал, боловсон хүчнээ гүүр барих газарт илгээх, гүүр барих ажлыг цагт нь дуусгах гэх мэтийн санал оруулдаг байна.

Гурав. Монголын талаас тавьдаг гол саналууд гэвэл:

1. Хоёр тал худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг дунд хугацааны хөтөлбөрийн үндсэн дээр хөгжүүлэх асуудлыг судлан боловсруулж, хэрэгжүүлэх чиглэлээр хоёр тал идэвхтэй ажиллах;

2. Талууд ДХБ-ын үндсэн зарчмыг баримтлан худалдааг улам чөлөөтэй болгох, аливаа саад тогторыг арилгах, хоёр талаас худалдаанд оролцогчдод, хил гаалийн шуурхай үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг харилцан авч хэрэгжүүлэх;

3. Хилийн боомтуудад хийж байгаа худалдааг олон улсын жишигт нийцүүлэн өөрчлөх талаар хоёр тал анхаарч, түр хугацаагаар ажилладаг боомтуудад хийж байгаа худалдаанд тавих шаардлагыг нэн даруй өндөржүүлэн олон улсын худалдааны стандарт, шаардлагад нийцсэн үйл ажиллагаа явуулах шаардлагыг өөр өөрийн худалдаачдад тавьж, хэвшүүлэх аргаа хэмжээ авах;

4. Монгол Улсын нефть бүтээгдэхүүний хангамжид дэмжлэг үзүүлэх үүднээс Хөх хотын Нефтийн үйлдвэрээс Монгол Улсад нийлүүлэх авто бензин болон нефтийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх асуудлыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

5. Шингэрүүлсэн хий хадгалалт, тээвэрлэлтийн асуудлыг хоёр талаас ярилцаж шийдвэрлэх, шийдвэрлэсэн тохиолдолд эхний ээлжинд жилд 2000 тонн шингэрүүлэн хий нийлүүлэх;

6. Нүүрсийг хийжүүлэх болон гүн боловсруулах чиглэлээр хамтран ажиллах зорилгоор нүүрсний аль нэг ордыг сонгон орчин үеийн нүүрсний цэвэр технологийг ашиглан эрчим хүч үйлдвэрлэх шинэ эх үүсвэр барих талаар хамтран ажиллах;

7. Монгол Улсын хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн орчинг танилцуулах, мэдээлэл өгөх, хөрөнгө оруулалтыг татах зорилгоор бизнес уулзалтыг Өвөр Монголын томоохон хот, аймгуудад хамтран зохион байгуулах;

8. “Үндэсний тохирлын тэмдэг” хэрэглэх эрхийг Монгол Улсад чанартай бараа бүтээгдэхүүн экспортолдог БНХАУ-ын байгууллага,

аж ахуйн нэгжүүдэд олгох ажлыг улам эрчимжүүлэх;

9. Оюуны өмчийн эрхийн худалдааны талаархи хэлэлцээрийг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах;

10. Төв суурин газрын ногоон байгууламжийг өргөтгөх, элсний нүүдэл, шар шороон шуурганы нөлөөллийг багасгахад Өвөр Монголоос туслалцаа авах;

11. ӨМӨЗО-ны Ардын Засгийн газрын тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаатай шууд харилцаа холбоо тогтоох;

12. Түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлах, номын сан, ном хэвлэлийн талаар хамтран ажиллах;

13. Монголын соёл урлагийн арилжааны арга хэмжээ /урлагийн тоглолт, үзэсгэлэн/ зохион байгуулах;

14. Эрүүл мэндийн салбарт хамтын ажиллагаагаа өргөжүүлж ӨМӨЗО-ны томоохон эмнэлгүүдтэй хамтарсан эмнэлэг байгуулах талаар тодорхой санал боловсруулах чиглэлээр хамтарч ажиллах;

15. Хил орчмын хамтын ажиллагааг идэвхжүүлэх, эрчим хүчний экспорт импортын чиглэлээр хамтран ажиллах;

16. Өвөр монголын авто замын байгууллагатай харилцаа тогтоох, туршлага солилцох, уулзалт зохион байгуулах;

17. Өвөр Монголын аялал жуулчлалын газартай хамтран зохион байгуулж буй “Хил орчмын аялал жуулчлалыг зохицуулах хурал”-ыг тогтмол үргэлжлүүлэн зохион байгуулах;

18. Өвөр Монголын талаас, Монголын жижиг, дунд үйлдвэрлэлийн чиглэлээр бизнес инкубатор байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх, мэргэжилтэй ажилчид бэлтгэх чиглэлээр сургалт зохион байгуулахад дэмжлэг өгөх;

19. Өвөр Монголтой шууд харилцаа тогтоож, “Дархан” аж үйлдвэрийн паркт БНХАУ-ын хөрөнгө оруулалттай үйлдвэрүүдийг байршуулах талаар хамтран ажиллах;

20. Хавиргын боомтоос Чойбалсан хот хүртэлх замыг Хятадын талын хөрөнгө оруулалтаар шинэчлэн тавих;

21. Хэнтий, Говьсүмбэр, Говь-Алтай, Өмнөговь, Дорноговь, Дархан-Уул Орхон, Дорнод, Баянхонгор аймгууд ӨМӨЗО-ны аймаг, хошуудтай шууд хамтын ажиллагаа тогтоох, үйлдвэрлэл, үйлчилгээ, соёл, боловсрол, эрүүл мэндийн салбарт хамтран ажиллах;

22. Биотехнологи, генетикийн чиглэлээр хамтран ажиллах ялангуяа энэ салбарт ӨМӨЗО-ны эрдэмтэд, эрдэм шинжилгээний байгууллага, аж ахуйн нэгжийн олсон амжилт, ажлын туршлагаас суралцах талаар хоёр тал судлан, тодорхой чиглэлээр хамтран ажиллах;

23. Худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор Улаанбаатар хотод ӨМӨЗО-ны Худалдаа, хөрөнгө оруулалтын төвийг, Хөх хотод Монголын Худалдаа, хөрөнгө оруулалтын төвийг байгуулах талаар хоёр тал санаачлага гарган ажиллах зэрэг саналуудыг оруулдаг байна.

Дээр дурьсан ӨМӨЗО болон Монголын талын саналуудын дийлэнхи хувь нь биелэлээ олож, зохих үр дүнд хүрч байна.

Дөрөв. Хоёр талын хамтын ажиллагааг улам эрчимжүүлэх тухай хэдэн санал

1. ӨМӨЗО болон Монгол Улсын хоёр талын эдийн засгийн мэргэжилтнийг оролцуулсан төлөөлөгчдийн бүлгэмийг зохион байгуулан, харилцан айлчлуулан судалгаа хийлгэж, хэлэлцэн тохирсон ажлыг хэрэгжүүлэхэд хяналт тавих;

2. ӨМӨЗО болон Монгол Улсын эдийн засаг худалдааны салбар нь харилцан нөхвөрлөх чанараар их байдаг онцлогийг үндэслэн, хоёр талын зах зээлийн эрэлт хэрэгцээ, орчин тойрон, нөхцөл бололцоог шинжлэх ухааны үндэслэлтэй дахин нарийвчлан судлан тогтоох;

3. Манай улсын хөршөө баяжуулах шинэ төрийн бодлогыг цаг алдалгүй зөв зохистой сурталчилж, Монгол Улсын ард түмэнд үнэн бодитой эдийн засгийн үр ашиг хүртээж байх;

4. Манай орны аж ахуйн нэгж Монголд хөрөнгө оруулахдаа зөвхөн ашиг их олох уул уурхайн салбарт л биш, аль чадахуйц бусад олон шинэ салбарыг эрэн хайж, хөрөнгө оруулахыг анхаарах;

5. Хятад, Монгол хоёр улс нь Дэлхий Худалдааны Байгууллагын гишүүн болсон болохоор түүний тогтолцооны хүрээнд дүрэм тогтоол журам горимыг нь сахиж үйл ажиллагаагаа явуулах;

6. Хятадаас баруун бүс нутгаа нээн хөгжүүлэх бодлого хэрэгжүүлж буй энэ үед хилийн худалдааны цар хүрээг өргөтгөж, өнөөгийн улирал бүр нэг удаа нээдэг зарим боомтыг сар бүр буюу удаан хугацаанд нээлттэй байдаг боомт болгон өөрчлөх;

7. Одоогийн хоёр талын банк санхүү, гааль, татвар, төмөр зам, боомтын шалган нэвтрүүлэх албанд оршиж байгаа авилга, хүнд сурталтай тууштай тэмцэж, хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааг эрүүл саруул хөгжүүлэх;

8. Өвөр Монгол болон Монгол Улс нь зөвхөн эдийн засаг худалдааны хүрээнд л биш соёл иргэншил, боловсрол, жуулчлал, амь ахуйг хамгаалах, гамшгаас аврах, эрүүлийг хамгаалах, халдварт өвчнөөс сэргийлэх гэх мэтийн салбарт хамтын ажиллагаагаа улам өргөтгөн эрчимжүүлэн хөгжүүлбэл зохилтой.